



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 05 өдөр

Дугаар АН94

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.8, Төсвийн тухай хуулийн 14.2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны ээлжит бус 10 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Монгол улс даяар зохион байгуулагдаж буй "Тэмбүүг устгая" арга хэмжээний хүрээнд "Хүчээ нэгтгэе" 1000 залуусын чуулга уулзалтаар Тэмбүү өвчнөөс урдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, гарын авлага түгээхэд зарцуулсан 1,000,000 төгрөгний дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Дээрх 1,000,000 (Нэг сая) төгрөгийг "Эрүүл иргэн-Эрхэм баялаг" дэд хөтөлбөрийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Базар), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Аззаяа) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД